



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/СГ

Улаанбаатар хот

Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийн
замналд зогсоол нэмэх, зогсоолын нэршил
өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/928 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Тээврийн газрын “Дүрэм”-ийн 2.5.3, 3.1.19 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, автобусны зогсоол хоорондын зайг ойртуулж иргэдийн эрэлт хэрэгцээг хангах үүднээс “Биогийн дэнж”, “Хабитат-1”, “Мод үржүүлэх-1”, “Цэргийн анги”, “5 толгой” зогсоолуудыг дайран өнгөрч буй чиглэлүүдийн зураглалд дээрх зогсоолуудыг нэмж нэг, хоёрдугаар хавсралтаар, Дандарбаатарын гудамжинд “Алдар спорт хороо”, “Генерал худалдааны төв”, Улаанхуарангийн гудамжинд “СОС хүүхдийн хотхон /урд/” зогсоолуудыг дайран өнгөрч буй чиглэлүүдийн зураглалд нэмж гурваас есдүгээр хавсралтаар, нийтийн тээврийн үйлчилгээний автобусны зогсоолын нэршлийг иргэдэд ойлгомжтой болгох үүднээс Чингэлтэйн 7 дугаар гудамж, Сүлжмэлийн үйлдвэрийн зогсоолуудыг дайран өнгөрч байгаа чиглэлүүдийг “Чиглэл ХХК”, “Та чи” болгон өөрчилж араваас гучин тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх үйлчилгээг 2017 оны 07 дугаар сарын 17-ны өдрөөс мөрдөж эхлэх чиглэлийн зураглалыг боловсруулахыг Тээврийн төлөвлөлт, технологийн хэлтэс /Д.Галбадрах/-т, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагатай хийсэн гэрээний хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулж, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс /Ц.Мөнхбат/-т, тухайн чиглэлүүдийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж, шуурхай зохицуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс /Э.Баярт/-т, үйлчилгээг батлагдсан замналын дагуу явуулах, зураглалд тусгагдсан зогсоолуудад зогсож хэвшүүлэх, цагийн хуваарийн мөрдөлтөд хяналт тавьж ажиллахыг Тээврийн хяналтын хэлтэс /Ц.Мягмар/-т тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Булгаа/-д үүрэг болгосугай.

